

СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/29

Баруун-Урт сум

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ны А/263 дугаар “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай” тушаалыг үндэслэн ТУШААХ нь:


1. Хүүхдийн эндэгдлийн магадлан хэлэлцэх комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, комиссын ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг мөрдөж ажиллахыг комиссын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
3. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс /Н.Нямгэрэл/- үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх комиссыг шинэчлэн байгуулах тухай” Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/76 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.БОЛОРМАА

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 05-р сарын 11-өдрийн
А/22-р тушаалын 1 дүгээр хавсралт



Хүүхдийн эндэгдлийг магадлан
хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн

- Дарга: ЭМГ-ын Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний
хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан
зохицуулагч /Хүүхдийн эндэгдэл хэлэлцэх үед/
Эх барих эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан
мэргэжилтэн /нярайн эрт үеийн эндэгдэл, амьгүй
төрөлт хэлэлцэх үед/
- Гишүүд: Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн
Чанарын албаны дарга / чанарын менежер
Өрхийн менежер
Сувилахуйн албаны дарга
Статистикч эмч, мэргэжилтэн
Шаардлагатай тохиолдолд холбогдох эмч, мэргэжилтэн
Нэгдсэн эмнэлгийн анатомийн эмгэг судлаач эмч

Эрүүл мэндийн газрын даргын
20.22 оны 05-р сарын 11-өдрийн
А/23-р тушаалын 1 дугаар хавсралт

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх комиссын ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Нярайн эндэгдлийг магадлан хэлэлцэх буюу аудит нь цаашид аудит гэнэ./ ураг болон нярайд үзүүлсэн тусламж үйлчилгээг нарийвчлан шүүн хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагаа бөгөөд тусламж үйлчилгээг чанартай, зөв зүйтэй явуулах, нас барсан тохиолдол бүрд дүн шинжилгээ, судалгаа, дүгнэлт хийж хэлэлцэх үйл ажиллагаа болно.

Хоёр. Зорилго

Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, жирэмсэн эмэгтэй болон шинээр төрсөн хүүхдийн амьдрах чадвар боломжийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч мэргэжилтний ажлын дутагдал болон амжилтыг мэдээлж, тэдний мэдлэг ур чадварыг тогтмол дээшлүүлэх, алдаа дутагдлыг давтахаас сэргийлэх ба бүх оролцогч талуудын туршлагыг солилцож, мэдлэгийг дээшлүүлэхэд оршино. Аудит хийснээр сэргийлэх боломжтой нас баралтыг бууруулах боломж бүрдэнэ.

Гурав. Комиссын удирдлага, зохион байгуулалт

Комисс нь Эрүүл мэндийн газрын шийдвэрээр байгуулагдах бөгөөд хүний бүрэлдэхүүнтэй, орон тооны бус байна. Комисс нь дарга, нарийн бичиг, гишүүдээс бүрдэнэ.

Комиссын ажиллах хэлбэр нь эндэгдэлд дотоод аудит хийх, хуралдаан зохион байгуулах ба хуралдааныг улиралд хийх бөгөөд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай тохиолдолд зарлан хуралдуулна. Комиссын дарга, түүний эзгүй үед ажил хариуцсан мэргэжилтэн санал хүргүүлж зарлан хуралдуулна.

Дөрөв. Комиссын эрх үүрэг

Аудитыг дараах үе шаттайгаар явуулна.

- 1, Эндсэн тохиолдлуудыг нэг бүрчлэн бүртгэж, мэдээллийг цуглуулах
- 2, Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- 3, Дүгнэлтийг үндэслэн асуудлыг хурлаар магадлан хэлэлцэж, асуудлыг нотолгоонд тулгуурлан хэрхэн шийдвэрлэх арга замыг гаргах, Эндэгдэл хэлэлцэх хурлыг комиссын дарга удирдаж явуулна.

Комиссын гишүүд мэргэжлийн чиглэлээрээ хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох асуудлын дагуу санал, дүгнэлт гаргадаг байх.

Комиссын нарийн бичгийн дарга нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, шийдвэр гаргах ба түүнд дарга, нарийн бичгийн дарга болон хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын хүрээнд эндэгдэл хэлэлцэх хуралдаанд холбогдох мэргэжилтэн, хуулийн зөвлөх болон шинжээч эмч нарыг татан оролцуулах, ажлын хэсэг томилон асуудлыг нягтлан шалгах, үнэлгээ хийлгэх, санал дүгнэлт гаргуулна.

Эндэгдэл хэлэлцэх хурлын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь ил тод байдлыг хангасан байна.

Хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг ЭМГ-ын даргад танилцуулна.

Тав. Комиссын нарийн бичгийн даргын чиг үүрэг

Хуралдаанаар хэлэлцэх асуудал, танилцуулгыг бэлдэж, материалыг хурал болохоос ажлын 3-5 хоногийн өмнө гишүүдэд, холбогдох эмнэлгийн мэргэжилтнүүдэд цахим болон цаасан хэлбэрээр тараан, хурлын зарыг мөн хугацаанд хүргэж, ирцийг бүрдүүлнэ.

Хуралдааны тэмдэглэл хөтөлж, зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

Нарийн бичиг нь хурлын архив, бичиг хэргийг хөтлөн явуулна.